

# С И Т И У Н И ВЕРСИТИ

2025 оны II сар

77442244

info@citi.edu.mn

www.citi.edu.mn

CITI University

NEWS

- “БИДНИЙ БАХАРХАЛ”
- “ОЮУТНЫ ТАЛБАР”
- “СИТИ БРЭНД”
- “CONGRATULATIONS”
- “СИТИ СПОРТ”
- “МАНАЙ БАГШ”
- “НОМ ЯРЬЖ ӨГЬЕ”
- “СИТИ NEWS”
- “АМЖИЛТЫН ТҮҮХ”

## “МАНАЙ БАГШ”

### Б.ГРЕГОРИ: МОНГОЛ ОЮУТНУУД БАГШИЙГ МАШ ИХ ХҮНДЭЛДЭГ

Архитектур, дизайны сургуулийн англи хэл, математикийн багш, математикийн ухааны доктор Б.Грегориой ярилцлаа.

-Таны багшлах замнал хэрхэн эхэлсэн вэ?

-Би багаасаа математикийн хичээлд маш их сонирхолтой байсан. Энэ нь намайг уг салбарыг гүнзгийрүүлэн судлахад түлхэц болсон. Дараа нь би математикийн доктор хамгаалж, эрдэм шинжилгээний ажлаас багшлах карьер руугаа шилжсэн.

-“СИТИ” Их сургуульд хэрхэн ажиллах болсон бэ?

-Би Франц улсын иргэн. Анх Монголд зургаан сарын хугацаатай оюутны визээр ирсэн. Энэ хугацаанд Монгол Улсад амьдрах, ажиллах сонирхол төрж, одоо зургаан жил болж байна. Монгол хүмүүсийн найрсаг хандлага, амьдралын нөхцөл байдал надад их таалагдсан. “СИТИ” Их сургуультай холбогдсон түүх минь 2022 оноос л доо. 2022 оноос эхлэн “СИТИ” Их сургуулийн Архитектур, дизайны сургуульд англи хэл, дээд математик зааж байна. Сургуулийн багш нартай хамтран ажиллах боломж олдсонд ихээхэн таатай байдаг. 2022 оноос өмнө би Эрдэнэт хотод ажиллаж, амьдарч байсан юм.

-Оюутнуудын математик, англи



хэлний хичээлд хэрхэн ханддаг вэ?

-Математикт суралцах нь олон

хүний хувьд бэрхшээлтэй санагддаг байж болох юм. Оюутнууд математикийн хичээлд эхэндээ

Төгсгөл нь III нүүрт »

## “БИДНИЙ БАХАРХАЛ”

### Г.ГАНЦЭЦЭГ: ЕСДҮГЭЭР АНГИД БАЙХДАА ЭРГЭЖ БУЦАЛТГҮЙ “СИТИ” ИХ СУРГУУЛИЙГ СОНГОСОН

Урлагийн сургуулийн Жүжиглэх, найруулах урлагийн III курсийн оюутан Г.Ганцэцэгтэй ярилцлаа.

-“Miss Tourism World” тэмцээнээс “Miss Photogenic” шагнал хүртжээ. Баяр хүргэе. Энэхүү тэмцээнд хэрхэн оролцох болсон талаар ярилцлагаа эхэлжэ?

-Баярлалаа. Сэтгэл маш өндөр байна. Тэмцээнд оролцох болсон шалтгаан маань өөрийгөө сорих, цаашлаад эх орныхоо нэрийг гаргах, аавынхаа нэрийг дэлхийн тайзан дээр бахархалтайгаар дуудуулахыг хүссэн.

-Өөрийнхөө талаар дэлгэрэнгүй танилцуулаач?

-Намайг Ганзоригийн Ганцэцэг гэдэг. Би таван хүүхэдтэй айлын дунд охин нь. Хоёр ах, ихэр эмэгтэй дүүтэй. “СИТИ” Их сургуулийн Жүжиглэх урлагийн III курсийн оюутан. Мөн “Торго модел” агентлагт Азийн “хатан хаан” мисс, модел Г.Оюунгэрэлийн шавь. Би “Miss World Mongolia” үндэсний ялагч шалгаруулах



тэмцээний “Зэс эрдэнэ”-ийн шагнал хүртэж байсан.

-“СИТИ” Их сургуулийг хэрхэн сонгох болсон бэ?

-Би багаасаа л загвар өмсөгч, жүжигчин болохыг мөрөөддөг байсан. Ахлах ангидаа хувцас дизайнер болох мөрөөдөлтэй байсан ч эцэст нь зүрх сэтгэлээ дагаж жүжигчин мэргэжлийг сонгосон.

Төгсгөл нь III нүүрт »

## “ТӨГСӨГЧИЙН АМЖИЛТЫН ТҮҮХ”

### Д.ДАГВАДОРЖ: СОНГОДОГ УРЛАГ ГЭДЭГ САХИЛГА БАТ, УР ЧАДВАР ШААРДДАГ МЭРГЭЖИЛ

“СИТИ” Их сургуулийн төгсөгч, Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан, ОХУ-ын Мариинский театрын гоцлол дуучин Д.Дагвадоржтой ярилцлаа.

-Дуурийн урлагт анх хэрхэн хөл тавьж байсан бэ. Багаасаа л дуулдаг хүүхэд байв уу?

-Би багаасаа л дуулдаг, бүжиглэдэг, хөгжим тоглодог хүүхэд байсан. Угтаа эстрадын дуучин болно гэж мөрөөддөг байлаа. Ингээд хоёр жил эстрад, хоёр жил дуурийн чиглэлээр суралцаж төгссөн.

- Та “СИТИ” Их сургуулийг хэдэн

онд төгссөн бэ. Ямар багшийн шавь бэ?

-Би 2010 онд “СИТИ” Их сургуулийг Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан А.Сайнбаяр багшийн удирдлаган дор “Дуурийн дуулаач”-ийн мэргэжлээр төгссөн. Багш маань дуурийн урлагт гүнзгий ойлголт, мэдлэг олгож, хичээл, сургалт бүрээр урлагийн талаарх ойлголтыг минь өргөжүүлж байсан. Багшийн маань зөвлөмж, арга зүй миний дуурийн урлагт амжилттай хөл тавихад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж боддог.

Төгсгөл нь II нүүрт »

## “ОЮУТНЫ ТАЛБАР”

### “СИТИ” Их сургуулийн эрхэм оюутан залуус аа!

“СИТИ” Их сургуулийн эрхэм оюутан залуус та бүхэнд өөрийн үзэл бодлоо олон нийтэд хүргэх, сэтгэн бодох, бичих ур чадвараа нээх гайхалтай боломжийг CITI CAMPUS NEWS олгож байна. Шинэлэг санал санаачилга, сонирхолтой мэдээ мэдээлэл, нийтлэлүүдээ бусдад хүргэхийг хүсч байвал бидэнтэй нэгдээрэй. “СИТИ” Их сургуулийн оюутан бүрт бидний үүд хаалга нээлттэй.

## “ТӨГСӨГЧИЙН АМЖИЛТЫН ТҮҮХ”

**Д.ДАГВАДОРЖ: СОНГОДОГ УРЛАГ ГЭДЭГ САХИЛГА БАТ, УР ЧАДВАР ШААРДДАГ МЭРГЭЖИЛ**

» Түүрүү нь I нүүрт

Сургуулиа ч маш их хүндэтгэж явдаг. **-Олон уралдаан тэмцээнд олон амжилт үзүүлсэн байдаг. Тэр бүхнээсээ дурдаач?**

-Сургуулиа төгсөөд 2010 оноос “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Соёл, урлагийн цогцолборын Эрдэнэт дуу бүжгийн чуулгад дуучнаар ажлын гараагаа эхлүүлж байлаа. 2019 онд ОХУ-ын Улан-Үдэ хотноо зохиогдсон “Байкальский международный конкурс-III вокалистов” олон улсын уралдааны тэргүүн байр хүртсэн. Түүнээсээ маш их урам авч, дуурийн дуучин чиглэлээр гүнзгийүүлэн суралцах, дуулахыг хүссэн. Энэ тэмцээний дараа ОХУ-ын Буриад улсын Дуурь бүжгийн академик театр, Владивосток хотын “Марийнский театр” зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагуудаас гэрээгээр ажиллах саналууд ирсэн. Ингээд дуулах ур чадвараа нэмэгдүүлэх, эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөх хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргийг хүлээж мэргэжлийн урлагийн байгууллагуудын саналыг хүлээн авч ОХУ-ын Буриад улсын Дуурь бүжгийн академик театр гоцлол дуучнаар ажиллах болсон. Энэ хугацаандаа Ж.Бизе КАРМЕН дуурийн Дон Хозе гол дүр, Ж.Верди АИДА дуурийн Радамес гол дүр, Ж.Бизе КАРМЕН дуурийн Дон Хозе гол дүрийг бүтээж, Улан-Үдэ хотноо зохиогдсон “БАЙКАЛЬСКИЙ МЕЖДУНАРОДНЫЙ КОНКУРС-III ВОКАЛИСТОВ” уралдаанд оролцож ТЭРГҮҮН байрын шагнал, 2020 онд “XIII международного конкурса вокалистов им.народного артиста СССР ЛЛ.Линховоина” олон улсын дуурийн дуулаачдийн уралдааны ГРАН-ПРИ шагнал, ОХУ-ын ардын жүжигчин Дарима Лхасарановна Линховоинийн нэрэмжит шагнал, 2021 онд Итали улсын Наполи



хотод зохион байгуулагдсан Нэрт дуучин Энрико Карузийн 100 жилийн ойд зориулсан “Vencero” олон улсын дуурийн дуулаачдийн уралдааны финалист, 2022 онд “VI международного конкурса вокалистов им.народного артиста СССР К.И.Базарсадаева” олон улсын дуурийн дуулаачдийн уралдааны Тэргүүн байрын шагналыг тус тус хүртсэн. Түүнчлэн 2022 онд Болгар улсын Пловдив хотод зохиогдсон “The voice of kamen” олон улсын анхдугаар уралдааны Тусгай байр, 2023 онд ОХУ-д зохиогдсон ОХУ-ын Ардын жүжигчин Хибла Герзмавагийн нэрэмжит Олон улсын дуурийн дуулаачид болон концертмейстеруудын I уралдааны 38 орны 800 гаруй дуулаачдаас шалгарч “Дуурийн шилдэг 16

дуулаач”, Оросын нэрт хөгжмийн зохиолч И.Дунаевскийн нэрэмжит Олон улсын дуулаачдын 12 дахь удаагийн уралдааны 35+ дээш насны ангилалд “Академик вокал буюу Сонгодог”, “Эстрадаын дуу”, “Эх орон сэдэвт эстрадын дуу” төрлүүдэд Тэргүүн байр, Исаак Дунаевскийн урын сангийн “ШИЛДЭГ ДУУЧИН”, Сергей Рахманиновын мэндэлсний түүхт 150 жилийн ойн хүрээнд гардуулсан С.Рахманиновын урын сангийн “ШИЛДЭГ ДУУЧИН”, 2023 онд ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Соёлын санаачлагыг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа

“Ангажемент” олон улсын дуурийн дуулаачдын уралдаанд Тэргүүн байр, 2023 онд Монгол Улсын Ардын жүжигчин А.Энхтайваны нэрэмжит мэргэжлийн дуу дуулаачдын олон улсын анхдугаар уралдаанд III байрыг тус тус эзэлсэн байна. 2024 оноос ОХУ-ын Владивосток хотын Мариинский театрын гоцлол дуучнаар ажиллаж байна. 2024 онд Ж.Бизе Кармен дуурийн Дон Хозе гол дүр, 2025 оны 1 дүгээр сард Дж.Верди Аида дуурийн Радамесийн гол дүрд дуулаа. Одоо 2025 оны 2 дугаар сарын 20-нд Дж.Верди Макбет дуурийн Макдуфа дүрд дуулахаар бэтгэлээ хийж байна даа. **-Дуучин болох замд хамгийн том сорилт, туулсан бэрхшээл юу байв?**

-Одоо ч гэсэн сурах зүйл маш их.

Ялангуяа сонгодог урлаг гэдэг сахилга бат, ур чадвар шаарддаг мэргэжил. Магадгүй өдөр тутамд л бэрхшээл гарч ирдэг. Миний хоолой эрэгтэй хүний нарийн хоолой гэж явдаг учир хайрлаж, гамнаж явах хэрэгтэй байдаг даа. Энэ урлагт тасралтгүй суралцах, хөгжих хэрэгтэй.

**-Та ямар дуучнаас үлгэр дууриал авдаг вэ?**

-Би Итали улсын нэрт дуучин, дэлхийн од Luciano Pavarotti гэдэг дуучинг сонсож, үлгэр дууриалд авдаг даа.

**-Монголын дуурийн урлаг ямар шатандаа явж байна гэж хардаг вэ?**

-Азийн орнуудаас анхны дуурийн театр Монгол Улсад байгуулагдсан. Монгол Улс өөрийн үндэсний дуурь болон гадны дууриудийг эх орондоо сорчлон тавьж байна. Монголын дуурийн дуучид гадны оронд дуулж байна. Ингээд харахаар энэ урлагийн хөгжил өндөр байгааг харуулж байна.

**-Монголын сонсогчдын дуурийн урлагт хандах хандлага хэр өөрчлөгдөж байгаа гэж та бодож байна?**

-Монголын шинэ үеийн залуу дуучид дэлхийд амжилт гаргаж эхэлсэн нь сонсогчдын сонирхлыг ихээхэн нэмэгдүүлсэн. Залуучууд дуурийг илүү сонирхож үзэх болсон байна лээ.

**-Монголын дуурийн урлагийг олон улсад таниулахад юу хамгийн чухал гэж үзэж байна вэ?**

-Монголын өөрийн үндэсний дууриас сонголт хийж шинэчлэн найруулах эсхүл шинээр бүтээн толилуулах, олон улсад сурталчилах, олон улсын тайзан дээр тоглох зэрэг бодлогоор хөгжүүлэх хэрэгтэй гэж боддог.

Э.БЯМБАСҮРЭН

**РЕДАКЦЫН ЗУРВАС**

Эрхэм уншигчид аа, Шинэ оны анхны сарыг амжилт, бүтээлээр үдэж, хоёрдугаар сарын дугаараа та бүхэндээ хүргэж байгаадаа баяртай байна. “CITI CAMPUS NEWS”-ийн энэ удаагийн дугаарт Архитектур, дизайны сургуулийн математикийн багш, математикийн ухааны доктор Б.Грегори, “СИТИ” Их сургуулийн төгсөгч, Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан, дуучин Д.Дагвадорж, Урлагийн сургуулийн Жүжиглэх, найруулах урлагийн III курсийн оюутан Г.Ганцэцэг нарын ярилцлага багтлаа. Тэдний бүтээлч замнал, амжилт, сонирхолтой туршлагаас уншигчид олон шинэ зүйл мэдэх болно. Архитектур, дизайны сургуулийн математикийн багш, математикийн ухааны доктор Б.Грегори бидэнд оюутнуудад математикийн талаарх ойлголт, зөвлөмж өгсөн бол, дуучин Д.Дагвадорж хэрхэн дуурийн урлагт амжилттай хөл тавьсан, түүний амжилтын замнал, дуурийн урлаг

дахь сорилтуудын талаар ярилцав. Харин Урлагийн сургуулийн Жүжиглэх, найруулах урлагийн III курсийн оюутан Г.Ганцэцэг суралцаж буй мэргэжил, дэлхийн тэмцээн, уралдаанд орсон туршлагынхаа талаар ярилаа. Тэрээр сургуулиа сонгохдоо сургалтын орчин, багш нарын чадварыг хамгийн чухал гэж үзсэн бөгөөд 9 дүгээр ангид байхдаа шууд “СИТИ” Их сургуулийг эргэж буцалтгүй сонгосон гэдгээ хэлж байв. Энэ мэтчилэн энэ удаагийн дугаарт сургуулийн үйл явдлууд, оюутнуудын амжилт болон бусад сонирхолтой мэдээ мэдээллүүдийг бид багтаалаа. Бид уншигчидтайгаа илүү ойр байж, та бүхний санал, бодлыг сонсож, сонинхоо чанар, агуулгыг сайжруулахад үргэлж хичээх болно. “CITI CAMPUS NEWS” бол мэдээллийн эх сурвалж төдийгүй хамтдаа суралцах, хөгжих, амжилт бүтээлээ хуваалцах талбар билээ. Та бүхэн шинэ дугаараа шимтэн уншаарай.

“СИТИ CAMPUS NEWS” редакцын баг

**“СИТИ CAMPUS NEWS” СОНИНЫ РЕДАКЦ**

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ:

“СИТИ” Их сургууль

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:

Б.НОМИН-ЭРДЭНЭ

/“СИТИ” Их сургуулийн маркетингийн менежер/

СЭТГҮҮЛЧ:

Э.БЯМБАСҮРЭН

/“СИТИ” Их сургуулийн Сэтгүүл зүйн IV курсийн оюутан/

О.ЭНХСАРАН

/“СИТИ” Их сургуулийн Сэтгүүл зүйн III курсийн оюутан/

Л.ХИШИГСАЙХАН

/“СИТИ” Их сургуулийн Сэтгүүл зүйн I курсийн оюутан/

ХОЛБОО БАРИХ УТАС:

77442244

ЦАХИМ ХАЯГ:

Nomin-erdene.bazarragchaa@citi.edu.mn

## “МАНАЙ БАГШ”

### Б.ГРЕГОРИ: МОНГОЛ ОЮУТНУУД БАГШИЙГ МАШ ИХ ХҮНДЭЛДЭГ

» Түрүүч нь / нүүрт

бэрхшээлтэй тулгардаг ч тэдэнд асуудал шийдвэрлэх, логик сэтгэлгээ хөгжүүлэх боломж олгох замаар хичээлээ илүү сонирхолтой болгодог. Практик жишээнүүд, бодит төсөл дээр ажиллах нь оюутнуудад хичээлийн утга учрыг ойлгоход тусалдаг. Математик нь зөвхөн тооцоолол биш, харин бүтээлч сэтгэлгээний үндэс болж өгдөг. Монгол оюутнуудын хичээлдээ оролцох идэвх нь тун сайн. Мөн оюутнууд багшийг маш их хүндэлдэг. Англи хэлний хичээл гэхэд тэд шууд англиар яриад эхэлдэг. Англи хэл нь сайн биш оюутнуудын хувьд маш их хичээл зүтгэлтэй суралцдаг.

**-Математик, англи хэлний хичээлүүдийг хэрхэн холбон заадаг вэ?**

-Англи хэл, математикийн мэдлэг хоёулаа чухал. Архитектур, дизайны чиглэлээр суралцаж буй оюутнуудад англи хэл болон математикийн мэдлэг зүй ёсоор холбогддог. Англи хэлээр гадаад эх сурвалжтай ажиллах чадварыг хөгжүүлж, математикийн хичээлээр логик сэтгэлгээ, басуудлыг шийдэх чадварыг олгодог. Энэ



хоёр хичээлийг зэрэг судлах нь оюутнуудад хөгжил, бүтээлч чанар авчирдаг.

**-Математик нь орчин үеийн дизайны салбарт хэрхэн нөлөөлдөг вэ?**

-Математик нь орчин үеийн дизайны салбарт олон төрлийн нөлөө үзүүлдэг. 3D загварчлал, тоон загварчлал, архитектурын төлөвлөлт гэх мэт салбарууд зөвхөн математик, тооцоололгүйгээр оршин

тогтнохгүй. Математикийн үндсэн ойлголтууд, онолыг баримталж, бүтээлч хандлагаар орчин үеийн дизайны олон төрлийг үүсгэх боломжтой. Энэ тал дээр оюутнуудыг дэмжиж, тухайн салбарын суурь мэдлэгийг нь бататгаж өгдөг.

**-Та оюутнуудад юу зөвлөх вэ?**

-Би оюутнууддаа үргэлж хэлдэг. “Математик болон англи хэлний мэдлэгээ хослуулах нь таныг илүү бүтээлч, олон талт мэргэжилтэн

болгоно” гэж. Энэ хоёр салбарыг зэрэг сурах нь зөвхөн академик амжилт төдийгүй, амьдралынх нь олон талбарт тус болно Математик бол зөвхөн тоон тооцоолол төдийгүй, энэ нь асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч сэтгэлгээний үндэс болдог. Оюутнууддаа энэ чадварыг хөгжүүлж, өөрсдийгөө хөгжүүлэх боломжийг олгодог нь миний зорилго юм.

О.ЭНХСАРАН

## “БИДНИЙ БАХАРХАЛ”

» Түрүүч нь / нүүрт

Жүжигчин болох амар биш гэдгийг мэдэж байсан ч энэ мэргэжилд бүхнээ зориулахаар шийдсэн. “СИТИ” Их сургуулийг сонгох болсон шалтгаан ч онцгой. Нэн тэргүүнд чадварлаг багш нар, тэгээд сургалтын орчин. Би 9 дүгээр ангид байхдаа “СИТИ” Их сургууль руу утасдаж, сургуулийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг аваад ахлах ангиа төгсөөд шууд л эргэж буцалтгүй энэ сургуулиа сонгож байсан.

**-“Miss Tourism World” тэмцээний тухай эргээд орёе. Олон улсын бүсгүйчүүдтэй өрсөлдөхөд ямар байсан бэ?**

-Олон орны үзэсгэлэнт эмэгтэйчүүдтэй нэгэн гараанаас эхлэж, туршлага солилцож, олон орны соёлтой танилцаж, найзууд болсон маань хамгийн мартагдашгүй дурсамжтай мөчүүд болж үлдлээ. Бүх сорилтыг сандралгүй даван туулсан хэдий ч энэхүү тэмцээн маань миний хувьд маш том туршлага болсон. Дараа дараагийн тэмцээнүүддээ ихээхэн туршлага хуримтлууллаа гэж харж байна.

### Г.ГАНЦЭЦЭГ: ЕСДҮГЭЭР АНГИД БАЙХДАА ЭРГЭЖ БУЦАЛТГҮЙ “СИТИ” ИХ СУРГУУЛИЙГ СОНГОСОН



**-Тэмцээний хамгийн мартагдашгүй мөч юу байв?**

-“Монголиа, Ганзориг Ганцэцэг”

хэмээн тайзнаа зарлуулж, шагнал аваад тайзнаас буух үе. Тэр агшинг юутай ч зүйрлэшгүй, маш

гайхамшигтай байсан даа.

**-Урлагийн сургуулийн оюутны хувьд жүжиглэх ур чадвар тэмцээнд чинь нөлөөлсөн болов уу?**

-Мэдээж, жүжиглэх ур чадвар маань тэмцээнд нөлөөлсөн. Өөртөө итгэх итгэл, олон хүний өмнө сандралгүй гарах, өөрөөрөө байж, хийе гэж бодсон зүйлсээ тултал нь хийхэд энэ мэргэжлийн ур чадвар маш том нөлөөлөл үзүүлсэн гэж бодож байна.

**-Ирээдүйд өөрийн мэргэжлийн болон хувь хүний ямар зорилтууддаа анхаарах төлөвлөгөөтэй байна вэ?**

-Ирээдүйд олон зүйлийг хийхээр төлөвлөж байна. Чадахаасаа чадахгүй хүртлээ бүх зүйл дээр хичээнэ гэж өөртөө хэлдэг.

**-Дараа дараагийн тэмцээний тов гарсан уу?**

-Одоогоор дараагийн тэмцээний тов хараахан гараагүй байна.

Ц.ЦЭРЭНБЯМБА

## “СИТИ БРЭНД”


Оюутнууд, төгсөгч, багш ажилтан та бүхэнд “СИТИ” Их сургуулийн нэрийн бүтээгдэхүүнүүдийг санал болгож байна. Сургуулийнхаа бахархлыг илэрхийлэх нэрийн брэнд бүтээгдэхүүнүүдийг та бүхэн “СИТИ” Их сургуулийн А байрны 2 давхарт байрлах нэрийн брэнд дэлгүүр (Merchandise concept store) -ээс худалдан авах боломжтой. Түүнчлэн халуун кофег таньд санал болгож байна.

## “НОМ ЯРЬЖ ӨГЬЕ”

### “ТОП ИХ СУРГУУЛЬ ЮУГААРАА ТОП ВЭ”

Энэ удаа уншигч та бүхэнд зохиолч Сато Жинийн “ТОП ИХ СУРГУУЛЬ ЮУГААРАА ТОП ВЭ” номыг онцолж байна. Энэхүү ном нь дэлхийд тэргүүлэгч хоёр том их сургуулиар жишээлэн дээд боловсролын шинэчлэлийн талаар зохиолчийн үзэл бодлыг нэгтгэн уншигчдад хүргэсэн бүтээл юм. Сато Жиний ном нь боловсролын шинэчлэлийн чиг хандлагын талаар олон чухал асуулт тавьж, түүнд хариулт олоход чиглэгдсэн. Өнөө цагт дэлхий даяар өрнөж буй даяаршлын нөлөөгөөр боловсрол ямар шинэчлэл шаарддаг вэ?, Боловсролын агуулга, хэлбэр ямар байх ёстой вэ? зэрэг олон асуултын хариултыг энэ номноос авах боломжтой.

Түүнчлэн номонд гадаадын шилдэг туршлагаудыг Монголын боловсролын системд хэрхэн нутагшуулах, дээд боловсролын салбарт хэрэгжүүлэх шинэчлэлийг хэрхэн зөв хэрэгжүүлэх талаар олон зөвлөмж, гарын авлага багтсан байна. Энэ нь Монголын их сургуулиуд болон оюутнуудад ихээхэн ач холбогдолтой бөгөөд шинэчлэл хийхэд нь туслах болно. Зохиолч “Шилдэг



сургууль гэж ямар сургуулийг хэлэх вэ?” гэдэг асуулт дээр төвлөрч, шилдэг сургуулиудын тодорхойлолт, тэдгээр сургуулиудын ялгарах онцлогийг дэлгэрэнгүй

авч үзсэн. Тэрээр шилдэг сургууль гэдэг нь зөвхөн сурлагын амжилтаараа бус, суралцагчдаа хэрхэн элсүүлж, хэрхэн сургаж, түүнчлэн тэдний сурлагын амжилтыг



хэрхэн үнэлдэг талаарх ойлголтыг ч мөн судалсан. Мөн шилдэг сургуулиуд хоорондоо юугаараа ижил төстэй, юугаараа ялгаатай болохыг тайлбарлажээ.

Номын агуулга нь зөвхөн академик үзүүлэлтүүд төдийгүй, дэлхий даяар боловсролын шинэ хандлагууд, инноваци, олон улсын хамтын ажиллагаа болон дээд боловсролын өрсөлдөөнт зах зээл зэрэг асуудлуудыг хөндсөн байдаг. Сато Жиний бүтээл нь боловсролын системийг ойлгох, хөгжүүлэх хүсэлтэй хүн бүрт хэрэгцээтэй ном юм. Энэхүү номын хамгийн том

давуу тал нь дэлхий даяар тэргүүлэгч сургуулиудын жишээг ашиглан, боловсролын шинэчлэлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлсэн явдал юм.

Номонд дээд боловсролын систем, чанартай боловсрол олгох стратеги, инноваци, олон улсын боловсролын хандлагуудыг хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүй зөвлөмж өгчээ. Уншигч та бүхэн энэхүү номыг “СИТИ” Их сургуулийн Номын сангаас авч унших боломжтой.

**БЭЛТГЭСЭН НОМЫН  
САНЧ, МЭДЭЭЛЛИЙН  
АЖИЛТАН Б.САЙНТУЛГА**

## “СИТИ СПОРТ”

### СИТИ “АЯНГА” ЭМЭГТЭЙ БАГ 6 ХОЖИЛТОЙГООР ОЮУТНЫ ЛИГИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЖ БАЙНА

Сагсан бөмбөгийн Оюутны лиг үргэлжилсээр байна. СИТИ “АЯНГА” багийн нэгдүгээр сарын тоглолтыг тоймлон хүргэе.

СИТИ “АЯНГА” эмэгтэй баг 2025 оны нэгдүгээр сарын 25-нд УБТДС NIPE BRANCOS багтай тоглож 64-26 онооны харьцаатайгаар ялалт байгуулсан билээ. Уг тоглолтонд Ц.Саранцэцэг #12 14 оноо, 7 самбараас бөмбөг авалт, 3 оновчтой дамжуулалт, 3 бөмбөг таслалт хийж тоглолтын шилдгээр тодорсон. Мөн нэгдүгээр сарын 27-нд ОТИС ШИЛҮҮСНҮҮД багтай тоглож 48-35 онооны харьцаатайгаар хожиж ялалт байгуулсан бөгөөд уг тоглолтонд Л.Алтанцэцэг #4 17 оноо, 10 самбараас бөмбөг авалт, 4 оновчтой дамжуулалт, 2 бөмбөг таслалт хийж багаа хожилд хөтөлсөн юм. СИТИ “АЯНГА” багийн 2 дивизонд тоглодог СИТИ “АЯНГА-2” баг 2025 оны нэгдүгээр сарын 23-нд АУМ BULLS багтай 1 тоглолт хийсэн бөгөөд уг тоглолтод тэд 62-90-ийн харьцаатайгаар гайхалтай ялалт байгууллаа. Уг тоглолтод Ш.Булган-Эрдэнэ #5 16 минут талбай дээр тоглоходоо 18 оноо, 2 оновчтой дамжуулалт, 2 самбараас бөмбөг авалт хийж багаа хожилд хүргэсэн юм. СИТИ “АЯНГА” 1 дивизонд тоглодог СИТИ “АЯНГА-1” баг 2025 оны нэгдүгээр сарын 25-нд АШУИИС



DOCTORS багтай учраа таарж тоглон 76-44 онооны харьцаатайгаар хожлоо. Энэ тоглолтод Э.Лхагвадорж #17 18 оноо, 10 самбараас бөмбөг авалт, 3 бөмбөг таслалт хийж, маш сайн тоглолтыг үзүүллээ.

Ийнхүү СИТИ “Аянга” багийн тухайд эрэгтэй 1 дүгээр баг 4 хожил, 5 хожигдолтой явж байгаа бол, эрэгтэй 2 дугаар баг 5 хожил, 2 хожигдол, эмэгтэй баг 6 хожил, 3 хожигдолтой явж байна.

**Л.ХИШИГСАЙХАН**

## “CONGRATULATIONS”

### “СИТИ” ИХ СУРГУУЛИЙН БАГШ НАР ШАГНУУЛАВ

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас боловсролын салбарт оруулж буй үнэтэй хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, дараах багш нарт шагнал олгосныг өнөөдөр “СИТИ” Их сургуулийн ерөнхийлөгч, доктор, профессор Ц.Байгалмаа, Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Дамдинсүрэн, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Л.Отгонжаргал нар гардууллаа.

Үүнд:

**“БОЛОВСРОЛЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” хүндэт тэмдгээр:**

Урлагийн сургуулийн Дуулах ур зүйн багш Г.Гэрэлбаатар,

Урлагийн сургуулийн Концертмейстер багш Б.Оюунтуяа,

Гоо сайхны ухааны сургуулийн Сувилахуйн тэнхимийн эрхлэгч Г.Бор,

**Боловсрол, шинжлэх ухааны яамны “ЖУУХ БИЧИГ”-ээр:**

Архитектур, дизайны сургуулийн



захирал Э.Шинэзаяа,

Гоо сайхны ухааны сургуулийн make up-ын багш Л.Маралмаа нар тус тус шагнууллаа.

### ҮНДЭСНИЙ ХУВЦАСНЫ ЭСКИЗ ЗУРАХ УРАЛДААНЫ ЭЗЭД ТОДОРЛОО

“СИТИ” Их сургуулийн Архитектур дизайны сургууль “Түмэн торго” ХХК хамтран үндэсний хувцасны эскиз зурах уралдааныг “СИТИ” Их сургуулийн I-IV курсийн оюутнуудын дунд зохион байгуулж, шилдгүүдээ тодрууллаа.

**ШИНЭЛЭГ ШИЙДЭЛ БҮХИЙ ХУВЦАСНЫ ЭСКИЗ ШАГНАЛ:**

Хувцас дизайны IV курсийн оюутан Г.Номин-Эрдэнэ, Б.Азжаргал

**ТЭРГҮҮН БАЙР:**

IV курсийн оюутан Э.Мөнхтулга. Тэрбээр “Түмэн торго” ХХК-иас ажиллах урилга авлаа.

**ТАЛАРХЛЫН ШАГНАЛ:**

III курсийн оюутан Э.Ариун-Эрдэнэ үндэсний хувцасны загварын шинэ шийдэл боловсруулсан.


Уралдаанд шагналт байр эзэлсэн оюутнуудад “Түмэн торго” ХХК-тай хамтран ажиллаж, хувцасны загвар бүтээх материал болон цалинтай ажиллах санал тавьсан нь онцлох үйл явдал боллоо. Оюутнуудын бүтээлч ажиллагааг дэмжин нэрэмжит уралдаан зохион байгуулж, хамтран ажилласан “Түмэн торго” ХХК-д талархал илэрхийлье.

## CITI NEWS

“ДЭМБЭРЭЛЦЭРЭН САН”-ГИЙН  
ТЭТГЭЛЭГ ГАРДУУЛЛАА

Монгол Улсын гавьяат хуульч, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн анхны дарга, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, “СИТИ” Их сургуулийн Удирдах зөвлөлийн дарга агсан Дашдоржийн Дэмбэрэлцэрэнгийн нэрэмжит “Дэмбэрэлцэрэн сан”-гаас жил бүр уламжлал болгон тэтгэлэг гардуулдаг билээ. Энэхүү тэтгэлэгийг 2021 оноос эхлэн “СИТИ” Их сургуулийн Хууль зүйн сургуулийн

шилдэг оюутан болон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зарладаг эсээ бичлэгийн уралдааны шилдгүүдэд олгож байна. Тэгвэл “СИТИ” Их сургуулийн Ерөнхийлөгч, доктор, профессор Ц.Байгалмаа бусдыгаа манлайлан суралцсан тус сургуулийн Хууль зүйн сургуулийн II курсийн оюутан Н.Тэмүүлэнд 100 хувь хөнгөлөлттэй суралцах батламж гардуулан өглөө.

“СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ”  
СЭДЭВТ ЛЕКЦ БОЛОВ

“СИТИ” Их сургуулийн Бизнесийн сургуулиас ээлжит лекцийг зохион байгууллаа.

Лекцийн үеэр тус сургуулийн багш, доктор (Ph.D) Ч.Энхболд “Судалгааны ажлыг хийх арга зүй” сэдвээр:


Судалгааны ажлыг мэргэжлийн болон академик стандартын дагуу

хэрхэн боловсруулах; АРА, Chicago зэрэг эшлэлийн системийг зөв ашиглах; Академик форматингийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх; Судалгааны ажлын чанарыг олон улсын түвшинд хүргэхэд анхаарах шаардлагатай элементүүдийг онцлон тайлбарлалаа.

ШАНХАЙ ИХ СУРГУУЛИЙН ГАДААД  
ХАРИЛЦААНЫ АЛБАНЫ ДАРГА ВАН  
ЧЭНЬ ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛЛАА

“СИТИ” Их сургуулийн докторант, Шанхай их сургуулийн Гадаад харилцааны албаны дарга Ван Чэнь (Wang Chen) “Хүүхдийн хьюристик сэтгэхүйг хөгжүүлэх номын дизайны загварчлал” сэдвээр докторын зэрэг амжилттай хамгааллаа. Эрдэм шинжилгээний удирдагчаар доктор (Ph.D), дэд профессор Д.Наранцацрал ажилласан бөгөөд

албан ёсны шүүмжлэгчээр доктор (Ph.D), профессор Б.Баяртөр, Ц.Шаравцэрэн нар ажиллалаа. Энэхүү судалгаа нь боловсролын салбарт шинэ хандлага, шинэлэг арга зүйг бий болгож, хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах чухал ач холбогдолтой юм.

ХУВЦАС ДИЗАЙНЫ САЛБАР ДАХЬ  
СУДАЛГАА, ИННОВАЦИЙН ШИНЭ  
ХАНДЛАГУУД ӨРГӨЖИЖ БАЙНА

“СИТИ” Их сургуулийн Архитектур, дизайны сургуулийн Хувцас дизайны тэнхим судалгааны чиглэлүүдээ тодорхойлон, салбарт тулгамдсан асуудлуудын хүрээнд судалгааны баг байгуулан ажиллаж байна. 2024 онд “МОНГОЛ МАЛГАЙН ХИЙЦИЙН АРГАЧЛАЛ” сэдвээр судалгаа хийгдэж, малгай хийх арга, технологийн туршилтын сургалтууд зохион байгуулагдлаа.

Мөн Хувцас дизайны тэнхимийн багш нар дараах 3 чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж байна.

-Монгол үндэсний хувцасны

уламжлал, шинэчлэл:

Даавуу, торгоны үйлдвэрлэлийн судалгаа;

Дундад зууны Монгол язгууртны дээлний хээ чимэглэлийн судалгаа;

-Монгол малгайн төрөл, хийцийн судалгаа.

Хувцасны тренд ба инноваци:

Хиймэл оюун ухааны хэрэглээ;

-Дахин загварчлал (Re-design);

Шинэлэг материалын судалгаа.

Хувцасны шүүмж судлал ба социологи:

Шүүмжийн төрөл, аргачлал;

Хувцас загварын социологийн нөлөөллийн судалгаа.

## CITI NEWS

## “СИТИ” ИХ СУРГУУЛЬ ЭНЭТХЭГИЙН VIT ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ӨВЛИЙН WORKSHOP АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



“СИТИ” Их сургууль гадаад хамтын ажиллагааныхаа хүрээнд Энэтхэг улсын VIT их сургуулийн VIT School of Design сургуультай хамтран 14 хоногийн өвлийн workshop-ийг тус улсад амжилттай зохион байгууллаа. Энэхүү сургалтын гол зорилго нь оюутнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдсэн юм. Сургалтад “СИТИ” Их сургуулийн ерөнхийлөгч, доктор, профессор Ц.Байгалмаа, Архитектур, дизайны сургуулийн захирал Э.Шинэзаяа, Архитектур, дизайны сургуулийн II-IV курсийн оюутнууд оролцлоо. Мөн VIT их сургуулийн оюутнууд хамтран оролцсон бөгөөд сургалтын явцад хоёр улсын оюутнууд хамтран дизайны бүтээлүүд хийлээ. Тус сургалтын үр дүнд шилдгээр шалгарсан оюутны бүтээлийг олон улсын дизайны уралдаанд оролцуулахаар болсон бөгөөд энэ нь оюутнуудын бүтээлч чанар, ур

чадварыг олон улсад таниулах томоохон боломж болсон юм. Мөн сургалтын хүрээнд хоёр сургуулийн багш нар цаашид хамтран эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээр төлөвлөв. Энэхүү сургалтыг дэлхийн шилдэг их сургуулиудын нэг болох Сингапурын Nanyang Технологийн их сургуулийн багш Peer M. Satikh удирдан явуулсан бөгөөд сургалтын арга зүй, удирдлага, мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулагдсан юм. 14 хоногийн турш үргэлжилсэн энэхүү сургалт нь оюутнуудын бүтээлч сэтгэлгээ, хамтын ажиллагааны чадвар, олон улсын туршлага хуримтлуулахад онцгой хувь нэмэр оруулсан үйл явдал боллоо. Цаашид “СИТИ” Их сургууль болон VIT сургууль хамтран энэхүү үйл ажиллагааг жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар болсон нь хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал алхам болж байна.


## “СИТИ” ИХ СУРГУУЛЬ НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛНЭ



“СИТИ” Их сургуулийн ерөнхийлөгч, доктор, профессор Ц.Байгалмаа Баянгол дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн захирал Б.Гэрэлгатай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Энэхүү санамж бичиг нь хоёр талын хооронд боловсролын салбарт, ялангуяа

насан туршийн боловсролын чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой юм. Түүнчлэн талууд боловсролын насан туршийн суралцагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлд хамтарч ажиллахаар тохиролцлоо.

## “СИТИ” ИХ СУРГУУЛЬ КУБА УЛСТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛНЭ



“СИТИ” Их сургуулийн ерөнхийлөгч, доктор, профессор Ц.Байгалмаа Бүгд Найрамдах Куба Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд, ноён Хорхе Феррер Родригесийг хүлээн авч уулзлаа. Энэ уулзалтаар “СИТИ” Их сургуулиас Куба улсад 2024 онд дарааллан

болсон байгалийн гамшигт үзэгдэлд өртсөн ард иргэдэд 3,000,000 төгрөгийг хандивлаж, Элчин сайдад гардуулан өгөв. Мөн энэ үеэр “СИТИ” Их сургууль Куба улсын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх талаар санал солилцлоо.

## “СИТИ” ИХ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧДӨД ЗОРИУЛСАН ГРАДАЦИ ХИЙХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

“СИТИ” Их сургууль төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаагаар ажлын байранд шаардагдах ур чадварыг дахин сургах, сэргээн сануулах хэрэгцээний санал авдаг билээ. Тэгвэл энэ удаа Хувцас дизайны мэргэжлээр ажиллаж буй төгсөгчдөд ажлын байранд шаардагатай үлгэрийг хэмжээ чачын (размер рост) өөрчлөлтөөр олшруулах буюу градаци хийх арга техникийн давтан сургалт зохион байгуулж 2020-2024 оны төгсөгчид хамрагдлаа. Сургалтад хамрагдсан төгсөгчид градаци хийх үндсэн ойлголтууд, практик хэрэглээ,

программын ашиглалт зэрэг өргөн хүрээний мэдлэгийг эзэмшиж, ажлын байранд шаардагатай ур чадвараа бүрэн ашиглах, хувцасны загварыг мэргэжлийн түвшинд боловсруулах чадвараа ахиулсан юм. Мөн сургалтаар төгсөгчид гардан ажил гүйцэтгэх дадлага хийж, бодит төсөл дээр ажиллах замаар онол практик хослуулсан мэдлэгээ бататгалаа. Давтан сургалтын дараа төгсөгчдийн ажлын гүйцэтгэлд мэдэгдэхүйц ахиц гарч, ажил олгогчдын зүгээс эерэг үнэлгээ авсан нь уг сургалтын үр дүнг илтгэж буй юм.

## “СИТИ” ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНУУД БНСУ-Д ТАНИЛЦАХ ДАДЛАГА ХИЙХЭЭР НИСЛЭЭ



“СИТИ” Их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн Солонгос хэлний орчуулагчийн ангийн оюутнууд богино хугацааны танилцах дадлага хийхээр БНСУ-ын Сөүл хотыг зориллоо. Энэхүү дадлагын хугацаанд оюутнууд хамтран ажилладаг их сургуулиудад зочилж,

сургалтын орчинтой танилцах, орчуулгын ур чадвараа хөгжүүлэх, шинэ хүмүүстэй танилцах зэрэг олон сонирхолтой үйл ажиллагаанд оролцох юм. Мөн Солонгосын соёл, ёс заншилтай танилцах, түүхэн дурсгалт газруудаар аялах, хотын хөгжилтэй танилцах юм.